

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН
ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

"Албан журмын даатгагчдын холбооны дүрэм"-ийн
шинэчилсэн найруулгыг батлах тухай

Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12¹.9 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 10, 11 дүгээр зүйл, "Дүрмийг зөвшөөрөх тухай" Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/354 дугаар бүхий албан бичиг, Удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Албан журмын даатгагчдын холбооны дүрэм"-ийн шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор баталсугай.
2. Албан журмын даатгагчдын холбооны дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Цэвээнжав/-д даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Удирдах зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол, 2011 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 дүгээр, 2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 11 дүгээр, 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 31 дүгээр, 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 41 дүгээр, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар, 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Албан журмын даатгагчдын холбооны дүрмийг 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсонд тооцож, дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Б.БАТ

Албан журмын даатгагчдын холбооны
Удирдах зөвлөлийн 2017 оны
05 дугаар сарын 15 -ны өдрийн
01 дүгээр тогтоолын хавсралт

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН

ХОЛБООНЫ ДҮРЭМ

/шинэчилсэн найруулга/

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Албан журмын даатгагчдын холбоо (цаашид “Холбоо” гэх) нь Монгол Улсад албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, албан журмын даатгалын зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч ашгийн төлөө бус төрийн бус байгууллага мөн.

1.2.Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон албан журмын даатгалын бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэ дүрмийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

1.3.Холбоо нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд зааснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

1.4.Холбооны албан ёсны оноосон нэр "АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" англи хэл дээр "ASSOCIATION OF MANDATORY INSURERS" гэнэ.

1.5.Холбоо нь Монгол улс, Улаанбаатар хотод байрлана.

1.6.Холбоо нь өөрийн бэлгэдэл, туг, тамга, тэмдэгтэй байх бөгөөд цахим хаяг, албан бичиг хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.7.Холбоо нь 2011 оны 11 сарын 7-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа Монгол улсын хуулиар хязгаарлагдана.

ХОЁР.ХОЛБООНЫ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Холбооны зорилго нь албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, гишүүдийн ашиг сонирхол, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор хуульд заасан үйл ажиллагаа явуулахад оршино.

2.2.Холбоо нь энэ дүрмийн 2.1-д заасан зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна:

2.2.1. албан журмын даатгалын эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төрийн эрх бүхий байгууллагаас холбогдох эрх зүйн акт боловсруулах болон өөрчлөлт оруулахад санал хүргүүлэх, оролцох, хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах;

2.2.2. Холбооны гишүүдэд албан журмын даатгал эрхлэх хүрээнд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, гишүүн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, зааврыг баталж мөрдүүлэх болон бусад үйлчилгээ үзүүлэх;

- 2.2.3. Холбооны гишүүн байгууллага болон даатгуулагч, хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн өмнө гишүүдийн эрх ашгийг хамгаалах, уялдаа холбоог хангах, энэ тухай асуудлаар холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- 2.2.4. хуульд заасны дагуу албан журмын даатгалын сан бүрдүүлэх, даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөр олгох, олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх, даатгалын сангийн бүрдүүлэлт зарцуулалтын тайланг жил бүр гаргаж холбогдох байгууллагуудад тайлагнах;
- 2.2.5. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийн сүлжээ бий болгох, эрх бүхий байгууллагуудыг холбогдох мэдээллээр хангах;
- 2.2.6. даатгагч, даатгуулагч, хохирогчид хууль, журмын дагуу туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий албан журмын даатгалын шуурхай албыг зохион байгуулах, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авах;
- 2.2.7. албан журмын даатгалын хэрэгжилт болон олон улсын зарчим, хэм хэмжээг судалж, олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай хамтран ажиллах;
- 2.2.8. албан журмын даатгалын үйл ажиллагааг нийтэд таниулах, даатгалын тохиолдлыг бууруулахтай холбогдсон албан журмын даатгалын сургалт, сурталчилгаа явуулах.

ГУРАВ.ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

- 3.1.Санхүүгийн зохицуулах хорооноос албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь холбооны гишүүн болох үүрэгтэй. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Албан журмын даатгагчийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулна.
- 3.2.Холбоонд гишүүнээр шинээр элсэх өргөдлөө даатгагч Удирдах зөвлөлд гаргана. Удирдах зөвлөл тухайн даатгагчийн гишүүнчлэлийн асуудлаар хуралдаж шийдвэр гаргана.
- 3.3.Холбооноос гишүүн байгууллагадаа албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх гишүүний батламжийг өгнө.
- 3.4.Холбоо нь гишүүдийн талаар бүртгэлийг хөтөлнө.
- 3.5.Удирдах зөвлөл дараах тохиолдолд Холбооны гишүүний албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Санхүүгийн зохицуулах хороонд уламжилна:
- 3.5.1. гишүүн нь албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх Холбооны болон бусад гишүүдийн ашиг сонирхолд бодит хохирол учруулсан;
- 3.5.2. гишүүн нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, энэ дүрмийн 3.1-д заасан гэрээ болон Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрийг удаа дараа биелүүлээгүй;
- 3.6.Даатгагч нь Холбооны гишүүнээр элсэх үүргээ хэрэгжүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
- 3.6.1. Холбооноос тогтоосон стандартын дагуу гаргасан өргөдөл;
- 3.6.2. компанийн дүрмийн хуулбар;
- 3.6.3. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 3.6.4. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гэрчилгээний хуулбар;
- 3.6.5. элсэлтийн хураамж төлсөн баримт;

- 3.6.6. компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцийн байдал;
- 3.6.7. компанийн гүйцэтгэх захирлыг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 3.6.8. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу гаргасан компанийн санхүүгийн тайлан, төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайлан, нөөц сангийн тайлан /сүүлийн жилийн болон улирлын байдлаар/;
- 3.6.9. компанийн салбарын мэдээлэл.

ДӨРӨВ.ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Холбооны гишүүний эрх:

- 4.1.1. Холбооны дүрэмд заасны дагуу Холбооноос үзүүлэх үйлчилгээг хүртэх, мэргэжлийн туслалцаа авах;
- 4.1.2. Холбооны үйл ажиллагаа болон чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээлэл, зөвлөгөө авах;
- 4.1.3. Даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон Холбооноос зохион байгуулах арга хэмжээнд оролцох;
- 4.1.4. Холбооны үйл ажиллагаатай холбогдуулан холбогдох эрх бүхий этгээдэд санал, хүсэлт, гомдлоо бичгээр гаргах.

4.2.Холбооны гишүүний үүрэг:

- 4.2.1. үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм болон энэ дүрмийн 2.2.2 дахь заалтыг үндэслэн баталсан журам, зааврыг мөрдөх;
- 4.2.2. Холбоог санхүүгийн талаар дэмжиж, гишүүний татвараа цаг хугацаанд нь төлөх;
- 4.2.3. Холбооны дүрэм, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай оролцох;
- 4.2.4. албан журмын даатгалтай холбогдол бүхий судалгааны зорилготой мэдээ болон даатгалын гэрээ, нөхөн төлбөр, шуурхай албаны дуудлагын үнэн зөв мэдээллийг тухай бүр Холбоонд ирүүлэх;
- 4.2.5. элсэлтийн хураамжийг албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор, гишүүний татварыг тухайн жилийн 01 дүгээр сард багтаан төлөх.

ТАВ. ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1.Холбоо нь дараах бүтэцтэй байна:

- 5.1.1. Удирдах зөвлөл;
- 5.1.2. Ажлын алба.

5.2. Холбоо нь орон нутагт салбар нээж болно.

5.2.1. Салбар нь Компанийн тухай хуулийн 7.7 дахь хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд Холбооноос баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

ЗУРГАА. УДИРДАХ ЗӨВЛӨЛ

6.1. Удирдах Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд шинээр сонгогдож батлагдсан гишүүний бүрэн эрхийн хугацаа нь чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 352 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6.2. Даатгалын тухай хуулийн 12¹.2 дахь хэсэгт заасны дагуу холбооны удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо батална.

6.3. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөхөд дор дурдсан дарааллыг баримтлан батална:

6.3.1. Холбооны Ажлын алба энэ дүрмийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх байгууллагаас саналыг авч, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ;

~~6.3.2. Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд хуралдаж нууцаар санал хураан, дийлэнх олонхийн санал авсан хүнийг Удирдах зөвлөлийн даргаар сонгоно.~~

/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 352 дугаар тогтоолоор хассан/

6.4. Холбооны Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлж, энэ дүрмийн 6.3-т заасан дарааллыг баримтлан нөхөн сонгоно:

6.4.1. Эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

6.4.2. Үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж, өөрөө өргөдөл гаргасан;

6.4.3. Төлөөлж буй байгууллагын албан тушаалаас чөлөөлөгдсөн;

6.4.4. Гишүүний үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй гэж Удирдах зөвлөлийн гишүүдийн олонх шийдвэрлэсэн.

6.5. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

6.6. Удирдах зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.

6.7. Удирдах зөвлөлийн гишүүдийн 1/3-ээс багагүй нь шаардсанаар, эсхүл гүйцэтгэх захирлын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

6.8. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь оролцсон бол хүний нөөцтэйгээс холбоотой бусад асуудлыг цахим хаягаар санал ирүүлбэл ирцэд тооцож хуралднаагы хүчинтэйд тооцож, Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналыг үндэслэн шийдвэр гаргана.

6.9. Удирдах зөвлөлийн хуралдааныг тэмдэглэлээр баталгаажуулж, тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг заавал тэмдэглэнэ.

6.10. Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

6.11. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

6.11.1. Холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.11.2. Холбооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө болон Ажлын албаны бүтэц, орон тоог батлах;

6.11.3. Холбооны ажлын албаны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон төсвийн төслийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайланг хэлэлцэх;

6.11.4. Холбооны гүйцэтгэх захирлын томилох, чөлөөлөх;

6.11.5. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулах;

6.11.6. Шинээр гишүүн элсүүлэх асуудлыг шийдвэрлэх;

6.11.7. Холбооны үйл ажиллагааг жил бүр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд болон гишүүн байгууллагуудад тайлагнах;

6.11.8.Холбооны санхүүгийн хураангуй тайланг жил бүрийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;

6.11.9.хуульд заасан бусад эрх.

6.12.Удирдах зөвлөлийн дарга дараах бүрэн эрхтэй:

6.12.1.Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

6.12.2.Удирдах зөвлөлийн гишүүний ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

6.12.3.хууль тогтоомж, энэ дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор тушаал гаргах;

6.12.4.Удирдах зөвлөлийн дарга өөрийн эзгүй үед хуралдаан даргалагчийг томилох;

6.12.5.Удирдах зөвлөлийг төлөөлж Удирдах зөвлөлийн дарга гүйцэтгэх захиралтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, ажлын үр дүнг дүгнэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг тусгана.

6.13.Холбооны Удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирал өөрийн эрх үүргийн хүрээнд олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахыг хориглоно.

6.14.Холбооны Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэр хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг зөрчсөнийг илрүүлсэн болон тогтоогдсон бол шийдвэр гаргагч этгээд өмнөх шийдвэрийг хүчингүй болгох, тэдгээрт нийцүүлж өөрчлөх эрхтэй.

6.15.Холбооны Удирдах зөвлөл дэргэдээ Хяналтын зөвлөлтэй байна. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Удирдах зөвлөл баталж, мөрдүүлнэ.

Долоо. Ажлын алба

7.1.Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүргийг Холбооны гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, Удирдах зөвлөлөөс өгсөн үүргийн биелэлтийг хангана.

7.2. Ажлын алба нь Даатгалын тухай хуулийн 12¹.3 дахь хэсэгт заасан бүтэцтэй байна.

7.3.Ажлын алба нь байнгын орон тоотой ажилтантай байх бөгөөд түүнийг гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

7.4.Гүйцэтгэх захирал нь Даатгалын тухай хуулийн 12¹.3 дахь хэсэгт заасан алба, сангийн удирдлагыг томилж, чөлөөлөхдөө Удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

7.5.Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

7.5.1. зээлийн батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;

7.5.2. ял шийтгэлгүй;

7.5.3. санхүү, эдийн засаг, эсхүл хууль зүйн дээд боловсролтой, тухайн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай.

7.6. Гүйцэтгэх захирал дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.6.1. Удирдах зөвлөлийн өмнө Холбооны үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд нэгээс доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

7.6.2. Холбооны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

7.6.3. Холбооны тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний болон зардлын төсвийн төслийг боловсруулах, Удирдах зөвлөлд танилцуулж, батлуулах;

7.6.4. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.6.5.Холбооны эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан Ажлын албыг удирдах;

7.6.6.Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Холбоог дотоод, гадаадад төлөөлөх, өмч хөрөнгө захиран зарцуулах;

7.6.7. Удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлыг нь дүгнэж шагнаж урамшуулах, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцох, ажлаас чөлөөлөх;

НАЙМ. ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

8.1. Холбооны хөрөнгө Даатгалын тухай хуулийн 12¹.6 дахь хэсэг, Даатгалын сан Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

8.2.Холбооны гишүүний элсэлтийн хураамж болон дараа жилд төлөх татварын хэмжээг жил бүрийн 12 дугаар сард багтаан Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтооно.

8.3. Холбооны үйл ажиллагааны зардлыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалт, Удирдах зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсөвт багтаан санхүүжүүлнэ.

8.4.Холбоо нь банкны байгууллагад төгрөгийн болон валютын харилцах данстай байна.

8.5.Албан журмын даатгалын хэлбэр тус бүрээр сангуудыг байршуулах бөгөөд сан тус бүр бие даасан данстай байна.

8.6.Холбоо нь даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах бөгөөд уг сангийн үйл ажиллагаа, тайланд эрх бүхий байгууллага хяналт тавина.

8.7.Холбоо нь улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцлийг зохих хууль, журмын дагуу гаргаж, хуулийн хугацаанд нийгмийн даатгал, татварын албанд, үйл ажиллагааныхаа тайланг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгч байна.

ЕС. БУСАД

9.1. Холбоог өөрчлөн байгуулах асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.2.Эрх бүхий байгууллагаас Холбоог татан буулгах бол Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яамтай зөвшилцөн татан буулгах комиссыг томилно.

9.3. Холбоог татан буулгах тохиолдолд түүний төлөх бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хөрөнгийг татан буулгах комиссын шийдвэрийн дагуу зарцуулна.

9.4.Холбоо нь өөрийн гишүүн болон Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн болон бусад хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг хүлээхгүй.

9.6.Санхүүгийн зохицуулах хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврыг хуульд нийцүүлэн батлах зөвшөөрлийг олгож, Холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.